



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Сайншанд сум

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа

Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44163,
Утас: (705) 2-27-34

Цалин хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 46/234

тантай _____-ны № _____-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудал гэж үзлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлангаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай дүгнэлт" өгөх үндэслэл болно. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан нийт авлагын 25.8 хувь болох 369.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага ба 268.6 сая төгрөгийн авлагыг хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр өгсөн байна. Мөн нийт авлагын 81% буюу 1,157.6 сая төгрөгийн авлагад холбогдох 379 иргэдтэй тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС 1-ын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн авлагын дүнд 30 харилцагчийн 4.5 сая төгрөгийн хасах дүнтэй авлага буюу өр төлбөр бүртгэлтэй байна. Энэ нь авлагын нийт дүнг бууруулах ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т бүх өр төлбөр, 20 дугаар зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Илрүүлэлтээр тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 4,006.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 1,664.4 сая төгрөгийн 97 гүйлгээ, 806.7 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 23 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 80.1 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60.4 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 29.6 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

НИК ХХК-Дорноговь салбартай байгуулсан "Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ"-ний 3.4 дэх заалтад "Худалдагч нь төлбөрийн дүнгээс 3 хувь хөнгөлөлт үзүүлнэ" гэсний дагуу хөнгөлөлтийг эдэлдэг бөгөөд тайлант хугацаанд 0.2 сая төгрөгийн хөнгөлөлт авсан, уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнадаггүй байна. Мөн шатахууны зарлагын гарсан ажил гүйлгээг тухай бүр бүртгэхгүйгээр бөөн дүнгээр бүртгэдэг, зарим зарцуулалт шаардах хуудасгүйгээр гарсан, мөн замын хуудастай уялддаггүй, автомашины спидометрийн заалт үнэн зөв эсэх нь эргэлзээтэй, орон нутагт томиллолтоор ажиллахад гадны 18 суудлын автомашин, 6 хүн тээврийн автомашиныг ашигласан байна. Шатахуун худалдан авалтын анхан шатны баримт болох гаргасан тушаал шийдвэрийн утга харилцан уялдаагүй, зөрүүтэй байна.

Энэ нь НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нийгмийн даатгалын байгууллагаас авсан судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн 40 гаруй ААНБ байгаагаас 7 ААНБ нь 140.9 сая төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн байна. Бусад ААНБ нь төлбөр төлөөгүй, холбогдох тооцоо, тайлан гаргаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолын хавсралт "Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам"-ын 3.7-д "ААНБ болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хариуцсан байгууллага санхүүгийн жилийн эцэст тухайн ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөр болон төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг эцэслэн нийлж, тооцоог дуусгавар болгоно", 3.8-д "Энэ журмын 2.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих болон ажиллуулж байгаа орон тоо, төлбөрийн хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ зэрэг холбогдох мэдээллийг хөдөлмөр, татвар, нийгмийн даатгал, бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагууд харилцан солилцож, мэдээллийн систем үүсгэж ажиллана. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн системийг удирдлагаар ханган ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 10 зорилт, 48 арга хэмжээний хэрэгжилт 89.6 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 77.2 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	1,085,296,271.94	1,842,343,586.94
33	АВЛАГА	1,085,296,271.94	1,842,343,586.94
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,072,344,863.39	1,429,146,778.39
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	382,104,445.00	682,298,004.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	84,664,250.00	122,235,450.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	280,547,368.94	256,919,524.94
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	35,934,999.45	97,354,999.45
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	50,990,000.00	49,990,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	238,103,800.00	211,188,800.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	-	9,160,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	12,681,703.55	412,927,103.55
33500	Бусад авлага	269,705.00	269,705.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	269,705.00	269,705.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,085,296,271.94	1,842,343,586.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	5,389,821.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,389,821.00	-
41300	Өглөг	3,803,921.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	967,921.00	-
41313	ХАОАТ-ын өглөг	967,921.00	-
41360	Бусад өглөг	2,836,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,836,000.00	-
41700	Хөтөлбөртэй холбоотой өглөг	1,585,900.00	-
41712	Хөдөлмөрийн харилцаа, үндсэн эрхийн хэрэгжилт	337,900.00	-
41716	Нийтийг хамарсан ажил	1,248,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,079,906,450.94	1,842,343,586.94
51	Засгийн газрын хувь оролцоо	1,079,906,450.94	1,842,343,586.94
51200	Хуримтлагдсан үр дүн	1,079,906,450.94	1,842,343,586.94
51210	Өмнөх үеийн үр дүн	1,079,906,450.94	1,085,296,271.94
51220	Тайлант үеийн үр дүн	-	757,047,315.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,085,296,271.94	1,842,343,586.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант жилийн гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	864,800,885.33	1,506,057,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	197,171,810.33	140,973,000.00
1200	Өмчийн орлого	-	140,973,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	197,171,810.33	140,973,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	140,973,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	667,629,075.00	1,365,084,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,629,075.00	1,365,084,600.00
	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	16,153,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	651,475,675.00	1,365,084,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	902,861,152.33	749,010,285.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,861,152.33	749,010,285.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,823,500.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,753,000.00	1,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00	1,500,000.00
	аудит баталгаажуулалт зэрэглэл	53,000.00	
	хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,070,500.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	891,037,652.33	747,510,285.00
	Бусад урсгал шилжүүлэг	184,155,401.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	194,871,107.33	55,845,482.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	194,871,107.33	55,845,482.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	512,011,144.00	249,917,624.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	512,011,144.00	249,917,624.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	441,747,179.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	441,747,179.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(38,060,267.06)	757,047,315.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(38,060,267.06)	757,047,315.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант жилийн гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	864,800,885.33	1,518,739,303.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	197,171,810.33	153,654,703.55
1200	Өмчийн орлого	-	153,654,703.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	197,171,810.33	153,654,703.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	197,171,810.33	140,973,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	12,681,703.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	667,629,075.00	1,365,084,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,629,075.00	1,365,084,600.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	16,153,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	651,475,675.00	1,365,084,600.00
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	313,896,585.00
145	Бусад орлого (олз)	-	313,896,585.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,200,069,897.94	1,832,635,888.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,200,069,897.94	1,832,635,888.55
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,679,100.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,855,500.00	1,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,552,500.00	1,500,000.00
	аудит баталгаажуулалт зэрэглэл	303,000.00	
	хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,520,600.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,185,693,797.94	1,831,135,888.55
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	201,072,160.88	211,153,014.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,072,160.88	211,153,014.55
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	503,049,186.06	507,537,195.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	503,049,186.06	507,537,195.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	481,572,451.00	1,112,445,679.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	481,572,451.00	1,112,445,679.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	(335,269,012.61)	(313,896,585.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	313,896,585.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	313,896,585.00
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	(335,269,012.61)	313,896,585.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	2021 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	1,079,906,450.94	1,079,906,450.94
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,079,906,450.94	1,079,906,450.94
8	2021 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	1,079,906,450.94	1,079,906,450.94
8	2022 оны 1-р сарын 1-ний үдэгдэл	1,079,906,450.94	1,079,906,450.94
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,389,821.00	5,389,821.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,085,296,271.94	1,085,296,271.94
15	Тайлант үеийн үр дүн	757,047,315.00	757,047,315.00
16	2022 оны 12-р сарын 31-ний үдэгдэл	1,842,343,586.94	1,842,343,586.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөлбөр, төслийн ангилал		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		ЗӨРҮҮ	
Код	Үзүүлэлт	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө
11	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	-	1,436,654,600.00	489	1,832,635,888.55	-489	-395,981,288.55
112	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	-	1,366,654,600.00	-	1,365,084,600.00	-	1,570,000.00
115	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	14	70,000,000.00	34	140,973,000.00	-20	-70,973,000.00
118	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	-	482	313,896,585.00	-482	-313,896,585.00
122	Өмнөх оны үлдэгдэл	-	-	-	12,681,703.55	-	-12,681,703.55
2	ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН	4,109	1,443,854,600.00	3,714	1,832,635,888.55	395	-388,781,288.55
21	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ	1,075	9,480,000.00	1,255	8,370,620.00	-180	1,109,380.00
211	Ганцаарчилсан	500	6,000,000.00	519	7,792,900.00	-19	-1,792,900.00
2111	Ажил мэргэжлээ сонгох, үйлчилгээ авах тухай зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/	-	-	-	500,000.00	-	-500,000.00
2112	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох /ганцаарчилсан/	-	-	-	6,952,000.00	-	-6,952,000.00
2113	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/	500	6,000,000.00	-	340,900.00	500	5,659,100.00
212	Бүлгээр	575	3,480,000.00	736	577,720.00	-161	2,902,280.00
2121	Ажил мэргэжлээ сонгох, үйлчилгээ авах тухай зөвлөгөө өгөх /бүлгээр/	-	-	-	117,720.00	-	-117,720.00
2123	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /бүлгээр/	575	3,480,000.00	-	460,000.00	575	3,020,000.00
22	Ажилд зуучлах үйлчилгээ	1,150	9,100,000.00	1,057	6,065,279.00	93	3,034,721.00
23	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	489	59,240,000.00	205	26,975,700.00	284	32,264,300.00
231	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	383	14,240,000.00	128	7,837,700.00	255	6,402,300.00
2311	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх	27	-	-	-	27	-
2312	Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	178	5,340,000.00	178	5,340,000.00	-	-
2313	Ажлын байранд зуучлах уулзалтанд бэлтгэх	178	8,900,000.00	50	2,497,700.00	128	6,402,300.00
232	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулах	105	37,800,000.00	77	19,138,000.00	28	18,662,000.00
2321	Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах	45	24,300,000.00	25	10,440,000.00	20	13,860,000.00
2322	Танхимын сургалт зохион байгуулах	30	7,200,000.00	36	7,032,000.00	-6	168,000.00
2323	Хоол унааны зардал	30	6,300,000.00	16	1,666,000.00	14	4,634,000.00
233	Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийн шалгаруулах	1	7,200,000.00	-	-	1	7,200,000.00
24	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	128	478,820,000.00	121	422,698,500.00	7	56,121,500.00
241	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	40	400,000,000.00	43	398,698,500.00	-3	1,301,500.00
242	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт явуулах	60	1,140,000.00	112	1,140,000.00	-52	-
2423	Хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулж үйл ажиллагаа эрхлэх	36	540,000.00	69	540,000.00	-33	-
2426	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт явуулах /санхүүгийн дэмлэг олгосны дараахь/	24	600,000.00	43	600,000.00	-19	-
243	Борлуулалтын дэмжлэг	21	35,200,000.00	5	2,700,000.00	16	32,500,000.00
245	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	7	42,480,000.00	4	20,160,000.00	3	22,320,000.00
25	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	415	48,446,000.00	207	25,170,500.00	208	23,275,500.00
251	Залуучуудад ажлын дадал туршлага, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэх	269	30,096,000.00	168	7,072,500.00	101	23,023,500.00
2512	Сургалтын зардал	1	4,800,000.00	57	4,800,000.00	-56	-
2515	Арга хэмжээ зохион байгуулах зардал - туслах ажилтны урамшуулал, бичиг хэрэг	200	3,000,000.00	60	1,482,500.00	140	1,517,500.00
2516	Ажил олгогчтой хийх уулзалт арга хэмжээ	68	1,020,000.00	51	790,000.00	17	230,000.00
2817	Дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээний зардал	34	9,180,000.00	-	-	34	9,180,000.00

2517	Дагалднаар суралцах ажилтны ажил олгогчоос болон ажилтнаас төлөх НДШ-н зардал	60	12,096,000.00	-	-	60	12,096,000.00
252	Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	2	18,000,000.00	25	18,000,000.00	-23	-
2522	Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг үзүүлэх	1	10,000,000.00	1	10,000,000.00	-	-
2523	Старт-Ап залуучуудад ментор хийх	1	8,000,000.00	24	8,000,000.00	-23	-
254	Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	50	350,000.00	14	98,000.00	36	252,000.00
26	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	68	173,995,600.00	48	91,192,300.00	20	82,803,300.00
261	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	30	150,000,000.00	18	90,000,000.00	12	60,000,000.00
262	Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	30	1,200,000.00	30	1,192,300.00	-	7,700.00
263	Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	4	17,570,000.00	-	-	4	17,570,000.00
264	Үйл ажиллагааны зардал	4	2,000,000.00	-	-	4	2,000,000.00
265	Гэрээт малчин өрхийн гишүүний нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх	4	3,225,600.00	-	-	4	3,225,600.00
27	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	137	169,087,000.00	97	152,342,000.00	40	16,745,000.00
271	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээ	106	149,059,000.00	79	147,309,000.00	27	1,750,000.00
2712	Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг /50 хувь эргэн төлөгдөх/	18	144,000,000.00	16	144,000,000.00	2	-
2716	Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт /өмнөх/	47	799,000.00	47	1,054,000.00	-	-255,000.00
2717	Борлуулалтын дэмжлэг	5	3,000,000.00	3	1,800,000.00	2	1,200,000.00
2718	Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт /өмнөх/	36	1,260,000.00	13	455,000.00	23	805,000.00
273	ХБИ Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	8	9,600,000.00	2	1,985,000.00	6	7,615,000.00
2731	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	8	9,600,000.00	2	1,985,000.00	6	7,615,000.00
274	Хөдөлмөр эрхэлтийн сургалт зохион байгуулах	28	10,428,000.00	16	3,048,000.00	12	7,380,000.00
2741	Танхимын сургалт зохион байгуулах	6	1,872,000.00	8	1,872,000.00	-2	-
2742	Үйлдвэр дээрхи сургалт зохион байгуулах	8	5,616,000.00	-	-	8	5,616,000.00
2743	Хоол унааны зардал	14	2,940,000.00	8	1,176,000.00	6	1,764,000.00
280	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	45	128,200,000.00	32	103,872,000.00	13	24,328,000.00
2801	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	23	24,840,000.00	9	2,587,500.00	14	22,252,500.00
2802	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	20	100,000,000.00	21	100,000,000.00	-1	-
2804	Хүүхэд хамгаалагч үйлчилгээг зохион байгуулах	2	3,360,000.00	2	1,284,500.00	-	2,075,500.00
281	Ногоон ажлын байр хөтөлбөр	570	228,000,000.00	564	224,000,000.00	6	4,000,000.00
2811	Мод тарих	500	200,000,000.00	504	199,000,000.00	-4	1,000,000.00
2812	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	70	28,000,000.00	60	25,000,000.00	10	3,000,000.00
282	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	50	24,136,000.00	128	15,015,800.00	-78	9,120,200.00
2821	Хүүхэд асран хамгаалах үйлчилгээ	3	12,400,000.00	1	10,000,000.00	2	2,400,000.00
28211	Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	1	10,000,000.00	1	10,000,000.00	-	-
28212	Хүүхэд харах төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх	2	2,400,000.00	-	-	2	2,400,000.00
2822	Богино хугацааны үр чадвар олгох сургалт, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалт	14	3,080,000.00	17	3,040,000.00	-3	40,000.00
28221	Мэргэжлийн болон цахим үр чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хосолсон сургалт	14	3,080,000.00	17	3,040,000.00	-3	40,000.00
2823	Цагаар ажиллахыг дэмжих	33	8,656,000.00	8	1,975,800.00	25	6,680,200.00
28231	Цагийн ажилд зуучлах	16	336,000.00	8	168,000.00	8	168,000.00
28232	Ажил олгогчид урамшуулал олгох	16	4,320,000.00	-	-	16	4,320,000.00
28233	Цагийн ажилд зуучлах өдөрлөг, яармаг	1	4,000,000.00	102	1,807,800.00	-101	2,192,200.00

	зохион байгуулах						
30	Хүүгийн хөнгөлөлт	1	350,000.00	-	-	1	350,000.00
301	Хүүгийн хөнгөлөлт	1	350,000.00	-	-	1	350,000.00
32	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	4,500,000.00		3,900,000.00	-	600,000.00
321	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	4,500,000.00		3,900,000.00	-	600,000.00
34	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	-	2,000,000.00	-	2,000,000.00	-	-
342	Програм хангамж, техник хангамжийн шинэчлэлт	-	2,000,000.00		2,000,000.00	-	-
35	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3-н талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт	-	8,000,000.00	-	7,519,400.00	-	480,600.00
351	Сургалт зөвлөлгөөн /хэлтсийн өөрийн/	-	8,000,000.00	-	7,519,400.00	-	480,600.00
36	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	-	11,500,000.00	-	11,140,300.00	-	359,700.00
361	Сурталчилгаа зохион байгуулах	-	11,500,000.00	-	11,140,300.00	-	359,700.00
37	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	12,000,000.00	-	7,834,500.00	-	4,165,500.00
373	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	12,000,000.00	-	7,834,500.00	-	4,165,500.00
39	Гарын авлага хэвлэмэл материал	-	2,000,000.00	-	1,931,500.00	-	68,500.00
391	Гарын авлага хэвлэмэл материал хэвлэх, олшруулах	-	2,000,000.00	-	1,931,500.00	-	68,500.00
43	Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай хуулийг шинэчлэх судалгаа, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах төсөл, арга хэмжээ	-	5,000,000.00	-	3,917,280.00	-	1,082,720.00
61	Төвлөрүүлэлт	-		-	718,690,209.55	-	
6110	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Төв сан	-	-	-	249,917,624.00	-	-249,917,624.00
6112	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Сангийн яам	-	-	-	63,978,961.00	-	-63,978,961.00
6120	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - Төв сан	-	70,000,000.00	-	55,845,482.00	-	14,154,518.00
6122	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - Сангийн яам	-	-	-	85,127,518.00	-	-85,127,518.00
6132	Санхүүжилтын буцаалт - Сангийн яам	-	-	-	251,138,921.00	-	-251,138,921.00
6152	Урьд оны үлдэгдэл - Сангийн яам	-	-	-	12,681,703.55	-	-12,681,703.55

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.5 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 6.5 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, батлагдсан төлөвлөгөө, санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх жилийн зэрэгцүүлэгдэх дүн тавигдаагүйг залруулсан.
2. 6.5 сая төгрөгийн авлага төлөлтийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 5 зөрчил² илэрснээс өмнөх оны аудитаар өгөгдсөн 2 албан шаардлагын биелэлт хэрэгжээгүй тул 2 хариуцлага тооцох албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 4,006.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 1,664.4 сая төгрөгийн 97 гүйлгээ, 806.7 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 23 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 80.1 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60.4 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 29.6 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Санхүүгийн тайланд тусгагдсан нийт авлагын 25.8 хувь болох 369.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага ба 268.6 сая төгрөгийн авлагыг хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан байна. Мөн нийт авлагын 81% буюу 1,157.6 сая төгрөгийн авлагад холбогдох 379 иргэдтэй тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт, УСНББОУС 1-ын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг” заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

1. Шатахууны тооцоо, тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд 6.8 сая төгрөгийн шатахуун авч, зарлагдсан. НИК ХХК-Дорноговь салбартай байгуулсан “Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ”-ний 3.4 дэх заалтад “Худалдагч нь төлбөрийн дүнгээс 3 хувь хөнгөлөлт үзүүлнэ” гэсний дагуу хөнгөлөлтийг эдэлдэг бөгөөд тайлант хугацаанд 0.2 сая төгрөгийн хөнгөлөлт авсан, уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнадаггүй байна. Мөн шатахууны зарлагын гарсан ажил гүйлгээг тухай бүр бүртгэхгүйгээр бөөн дүнгээр бүртгэдэг, зарим зарцуулалт шаардах хуудасгүйгээр гарсан, мөн замын хуудастай уялддаггүй, автомашины спидометрийн заалт үнэн зөв эсэх нь эргэлзээтэй, орон нутагт томилолтоор ажиллахад гадны 18 суудлын автомашин, 6 хүн тээврийн автомашиныг ашигласан байна. Шатахуун худалдан авалтын анхан шатны баримт болох гаргасан тушаал шийдвэрийн утга харилцан уялдаагүй, зөрүүтэй байна.

НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгах, шатахуун зарцуулалт хийгдсэн тухай бүр бүртгэл хөтлөх, цаашид алдааг давтан гаргахгүй байх

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авлагын дүнд 30 харилцагчийн хасах дүнтэй 4.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Энэ нь авлагын нийт дүнг бууруулж, бодит мэдээллээр хангахгүй үр дагавартай.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.”Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т бүх өр төлбөр, 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч бүрээр асуудлыг тодруулан, холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэх.

3. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын байгууллагаас авсан судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн 40 гаруй ААНБ байгаагаас 7 ААНБ нь 140.9 сая төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн байна. Бусад ААНБ нь төлбөр төлөөгүй, холбогдох тооцоо, тайлан гаргаагүй байна. Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй, орлого дутуу бүрдүүлэх, төлбөр цаг хугацаандаа төлөгдөхгүй байх үр дагавартай.

Мөн Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолын хавсралт “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын 3.7 ААНБ болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хариуцсан байгууллага санхүүгийн жилийн эцэст тухайн ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөр болон төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг эцэслэн нийлж, тооцоог дуусгавар болгоно, 3.8.Энэ журмын 2.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих болон ажиллуулж байгаа орон тоо,

төлбөрийн хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ зэрэг холбогдох мэдээллийг хөдөлмөр, татвар, нийгмийн даатгал, бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагууд харилцан солилцож, мэдээллийн систем үүсгэж ажиллана. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн системийг удирдлагаар ханган ажиллана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, гарсан тогтоол шийдвэрийн биелэлтэд анхаарч, ААНБ-уудтай хамтарч ажиллах.

Дээрх албан шаардлага, хариуцлага тооцох албан шаардлага, зөвлөмжийн биелэлтүүдийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлан, батлагдсан төлөвлөгөө, санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх жилийн зэрэгцүүлэгдэх дүн тавигдаагүй.	1	-			1	-	1	-				
6.5 сая төгрөгийн авлага төлөлтийг үр дүнгийн тайланд орлогоор алдаатай бүртгэсэн.	1	6,480.6			1	6,480.6	1	6,480.6				
Дүн	2	6,480.6			2	6,480.6	2	6,480.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд тусгагдсан нийт авлагын 25.8 хувь болох 369.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага ба 268.6 сая төгрөгийн авлагыг хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан байна. Мөн нийт авлагын 81% буюу 1,157.6 сая төгрөгийн авлагад холбогдох 379 иргэдтэй тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.	1									1		
НИК ХХК-Дорноговь салбартай байгуулсан "Газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ"-ний 3.4 дэх заалтад "Худалдагч нь төлбөрийн дүнгээс 3 хувь хөнгөлөлт үзүүлнэ" гэсний дагуу хөнгөлөлтийг эдэлдэг бөгөөд тайлант хугацаанд 0.2 сая төгрөгийн хөнгөлөлт авсан, уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнадаггүй байна. Мөн шатахууны зарлагын гарсан ажил гүйлгээг тухай бүр бүртгэхгүйгээр бөөн дүнгээр бүртгэдэг, зарим зарцуулалт шаардах хуудасгүйгээр гарсан, мөн замын хуудастай уялддаггүй, автомашины спидометрийн заалт үнэн зөв эсэх нь эргэлзээтэй, орон нутагт томиллолтоор ажиллахад гадны 18 суудлын автомашин, 6 хүн тээврийн автомашиныг ашигласан байна. Шатахуун худалдан авалтын анхан шатны баримт болох гаргасан тушаал шийдвэрийн утга харилцан уялдаагүй, зөрүүтэй байна.	1	221.7					1	221.7				
Авлагын дүнд 30 харилцагчийн хасах дүнтэй 4.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.	1	4,512.6					1	4,512.6				
Нийгмийн даатгалын байгууллагаас авсан судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн 40 гаруй ААНБ байгаагаас 7 ААНБ нь 140.9 сая төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн байна. Бусад ААНБ нь төлбөр төлөөгүй, холбогдох тооцоо, тайлан гаргаагүй байна.	1						1					
Дүн	4	4,734.3					3	4,734.3	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 4,006.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 1,664.4 сая төгрөгийн 97 гүйлгээ, 806.7 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 23 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 80.1 сая төгрөгийн орлогын 8 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 60.4 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 29.6 сая төгрөгийн 2 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
Дүн	1		-	-	1	-		